



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ

2018 оны 04 сарын 03 өдөр

Дугаар 342

Улаанбаатар хот

“Амгалан дулааны станц”
хязгаарлагдмал хариуцлагатай компанийн
дүрэмд өөрчлөлт оруулах тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 9, Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.1, 62.1.3 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1.Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2014-2015 онд хийгдсэн нийт 109,934,367,286.40 (нэг зуун есөн тэрбум есөн зуун гучин дөрвөн сая гурван зуун жаран долоон мянга, хоёр зуун наян зургаан төгрөг дөчин мөнгө) төгрөгийн хөрөнгийн эх үүсвэрийн дүнгээр “Амгалан дулааны станц” хязгаарлагдмал хариуцлагатай компанийн эзэмшигчийн өмч дэх төрийн өмчийн дүнг нэмэгдүүлэхийг зөвшөөрсүгэй.

2.“Амгалан дулааны станц” хязгаарлагдмал хариуцлагатай компанийн дүрмийн 3.3-т “Компанийн зарласан хувьцаа нь нэг бүрийн 100 төгрөгийн нэрлэсэн үнэтэй 350 000 000 (гурван зуун тавин сая) ширхэг энгийн хувьцаатай” гэснийг “нэг бүр нь 100 төгрөгийн нэрлэсэн үнэ бүхий 1,099,343,672 (нэг тэрбум ерэн есөн сая гурван зуун дөчин гурван мянга зургаан зуун далан хоёр) ширхэг энгийн хувьцаатай” гэж өөрчлөн найруулсугай.

3.“Амгалан дулааны станц” хязгаарлагдмал хариуцлагатай компанийн эзэмшигчийн өмч дэх төрийн өмчийн дүнд орсон өөрчлөлтийг холбогдох байгууллагад бүртгүүлэхийг компанийн гүйцэтгэх захирал Ш.Баянмөнхөд үүрэг болгосугай.

4.Энэхүү тогтоолын хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг Бодлого, төлөвлөлт удирдлагын хэлтсийн дарга Ц.Баяр-Эрдэнэд даалгасугай.

ДАРГА

ЗАХИРГАА ХУУЛЬ ЗҮЙН
ХЭЛТСИЙН ДАРГА



Ц.НЯМ-ОСОР

Б.ГАВАА